
Бүсийн олимпиад 2018

1. Найман оронтой A тооны зарим цифрийн байрыг хооронд нь сольж B тоог гаргажээ. $A + B = 20182019$ байж болох уу?

2. Суварганы дээд нүдэнд бичигдсэн тоо нь доор байрлах 2 нүдэнд бичигдсэн 2 тооны үржвэртэй тэнцүү байна. Хамгийн доод эгнээний нүднүүдэд 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10 тоонууд зурагт үзүүлсэн байдлаар бичигдсэн бол хамгийн дээд нүдэнд бичигдсэн тоо хэдэн тэгээр төгсөх вэ?



3. Цифрүүд нь буурах дараалалтай тоог *буурдаг* тоо гэж нэрлэе. Жишээ нь 310 нь буурдаг тоо, харин 12, 333 нь буурдаг тоо биш. 111-д хуваагддаг буурдаг тоо олдох уу?

4. Дөрвөлжин шугамтай цаасан дээр зурсан сондгой талтай квадратын төвийн нүдийг ухаж авчээ. Квадратын үлдэх хэсгийг зурагт үзүүлсэн 4 нүдтэй дүрсэд хувааж болохыг батал (дүрсийг яаж ч эргүүлж болно).

